



monlogistics
GROUP

2025 ОН III УЛИРЛЫН ТАЙЛАН

MSE:MLG

www.mlholding.mn



КОМПАНИЙН ТУХАЙ

2005 онд Монгол Улсад тээвэр зуучийн үйлчилгээний нэгэн шинэ хуудсыг эхлүүлж, цөөн хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж байсан Монложистикс Групп нь өнөөдөр 20 жилийнхээ ойн босгон дээр 1 толгой компани, 10 охин компани, 240 гаруй ажилтан, дэлхийн 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын тэргүүлэгч групп болон өргөжин тэлжээ. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд бид Монгол Улсын эдийн засгийн чухал салбар болох тээвэр ложистикийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, иргэдийн өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уурхайн түүхий эдийг экспортлох, хөрш болон гуравдагч орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг, карго зэрэг тээвэр ложистикийн бүх төрлийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн үзүүлсээр ирлээ. 20 жилийн турш бид харилцагч, ажилтнууд, түншүүдийнхээ итгэл дээр тулгуурлан, инновац, чанар, хариуцлагыг эрхэмлэж ажилласан бөгөөд энэ хугацаанд бизнесийн тогтвортой өсөлт, менежментийн шилдэг туршлага, дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай групп компанийг бий болгожээ. Монложистикс Холдинг ХК нь группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, тэдгээрт хүний нөөц, санхүү, мэдээллийн технологи, маркетинг, стратеги ба бизнес хөгжил, ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.



ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

III УЛИРЛЫН ТАЙЛАН 2025

ЭРХЭМ ЗОРИЛГО

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

АЛСЫН ХАРАА

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол Улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.



ҮНЭТ ЗҮЙЛС



Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтээл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.



Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.



Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол Улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.



Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.



Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.

ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монголын Тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

2006 ОН

Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас Гаалийн зуучлагчийн тусгай зөвшөөрлийг авав.

2010 ОН

Олон улсын тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

2014 ОН

Rebranding “Upgrade 10” төслийг амжилттай эхлүүлэв.

2016 ОН

2005 ОН

Монлогистикс Ворлдвайд ХХК анхны ууган компани байгуулагдав.



2009 ОН

Төмөр замын аюулгүй ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүлээн авав.



2011 ОН

Монголын гаалийн зуучлагчдын нэгдсэн холбооны гишүүнээр элсэв.



2015 ОН

ISO 9001:2008 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэв.





Оюу толгой компанийн албан ёсны тээврийн компаниар шалгарав.



Монложистикс Холдинг ХХК Толгой компани байгуулагдав.



Түүхий эдийн экспортын тээврийг эхлүүлж, Каус Аустралис ХХК-ийг байгуулав.



CORE системийн шинэчлэл хийгдэв. Группт 3 шинэ охин компани нэмэгдэв.

2018 ОН

2020 ОН

2022 ОН

2024 ОН



2017 ОН

2019 ОН

2021 ОН

2023 ОН

2025 ОН

Бүх тээврийг даатгалд хамруулах үйлчилгээг нэвтрүүлэв.

Монложистикс Транзит ХХК байгуулагдав.

Портфолио өргөжилт хийж, 3 охин компаниа байгуулав.


Монложистикс Холдинг ХХК Олон нийтэд нээлттэй компани болов.

Монложистикс Холдинг ХК Do good HUB ТББ-ыг байгуулав.

Монложистикс групп үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой



ГРУППИЙН БҮТЭЦ



MSE:MLG хувьцаа ангилал ахилаа.

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилал 2025 оны 9-р сард шинэчлэгдэж, Монложистикс Групп (MSE:MLG) нь I ангилал руу дэвшлээ. Монголын хөрөнгийн бирж дээрх хувьцаануудын арилжааны идэвх, зах зээлийн үнэлгээ, компанийнх нь засаглал, мэдээллийн ил тод байдал зэрэг олон шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэж 3 ангилдаг бөгөөд MSE:MLG хувьцаа маань ийнхүү Монголын хөрөнгийн зах зээлд I ангилалд арилжаалагдах 25 хувьцааны нэг боллоо.


Хувьцаа халааслах хөтөлбөр

Монложистикс Групп (MSE:MLG) нь 4,8 сая ширхэг хувьцаагаа нэгж бүрийг нь 210 төгрөгөөр үнэлж нээлттэй зах зээл дээрээс эргүүлэн худалдаж авахаа зарласан билээ. Хувьцаагаа халаасалсны үр дүнд хувьцааны эрэлт нэмэгдэж, арилжааны идэвхжил сайжрах, хувьцааны үнэ тогтвортой байх, есөх, хөрөнгө оруулалтын сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна.

2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 529,981,555.54 (таван зуун хорин есөн сая есөн зуун наян нэгэн мянга таван зуун тавин тав) төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг нээлттэй зах зээлээс эргүүлэн худалдаж аваад байна.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ




Оюутолгойн зэсийн баяжмалыг төмөр замаар тээвэрлэх тендерт шалгарав.

Оюутолгой ХХК-аас зарласан “Зэсийн баяжмалыг төмөр замаар экспортлох тээвэрлэгчийг сонгон шалгаруулах тухай” тендерт Монложистикс Ворлдвайд ХХК амжилттай оролцож, шалгарлаа. 2013 онд Оюутолгойн зэс, алтны ордыг ашиглаж эхэлсэн цагаас хойш экспортын тээврийг зөвхөн автомашинаар зохион байгуулж байсан бол энэхүү сонгон шалгаруулалтын үр дүнд тээврийн төрлийг нэмэгдүүлж, экспортын гарцыг өсгөх, нэг боомтын хамаарлыг бууруулах олон ач холбогдолтой юм. Бидний хувьд 2025 оны 10 сард эхний цувааг Цогтцэций – Зүүнбаян – Замын-Үүд – Эрээн гэсэн маршрутаар зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна.

MinePro Mongolia 2025-д оролцлоо.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн төрөлжсөн үйлчилгээ үзүүлэгч Монложистикс Групп нь Монголын эрдэс баялгийн салбарын хамгийн том арга хэмжээ болох MinePro Mongolia 2025-д тээвэр ложистикийн цогц шийдэл, төслийн ачаа, дараа төлбөрт уян хатан тээврийн нөхцөлүүдээ танилцуулж оролцлоо. Эрдэс баялгийн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, хариуцлагатай уул уурхайг өргөжүүлэн хөгжүүлэхэд тээвэр ложистикийн гүйцэтгэх үүрэг өндөр билээ.



Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллав.

Хөрөнгө оруулагчдад мэдээллээ ил тодоор, шуурхай, хүртээмжтэй хүргэх компанийн бодлогын хүрээнд Монложистикс групп нь үйл ажиллагааны тайлангаа улирал тутам тогтмол бэлтгэж, <https://investor.mlholding.mn/> цахим хуудсандаа болон МХБ-ын цахим хуудсанд байршуулдаг билээ. Бид 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, голлох үзүүлэлт, өсөлт болон стратегийн шинэчлэлүүдийг танилцуулах Earnings Call арга хэмжээг Capital Markets Mongolia компанитай хамтран 2025 оны 7-р сарын 30-ны өдөр зохион байгуулсан бол 2025 оны 8-р сарын 06-ны өдөр МХБ-ын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тайлангаа танилцууллаа.



Сагсан бөмбөгийн спортыг дэмжигч

Монложистикс Групп Монголын сагсан бөмбөгийн шилдэг багуудын нэг болох Сэлэнгэ Бодонс багтай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Энэхүү хамтын ажиллагаа нь баг тамирчдын амжилтад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ, Монголын сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй чухал үйл явдал юм. Мөн 2025 оны 5-р сарын 30-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Азийн аваргуудын лигийн зүүн бүсийн финалын тоглолтын хамтрагчаар ажиллалаа.



ОНЦЛОХ ТЭЭВЭР



monlogistics
EXPRESS

Монложистикс Экспресс ХХК нь 2025 оны гуравдугаар улиралд томоохон ханган нийлүүлэгчийн тэсэлгээний материалыг агаараар амжилттай тээвэрлэлээ. Тэсэлгээний материалыг агаараар тээвэрлэх нь өндөр эрсдэлтэй бөгөөд тусгай горимоор, аюулгүй ажиллагааг өндөр түвшинд шаардсан онцгой тээвэр билээ.

monlogistics
WORLDWIDE

Монложистикс Ворлдвайд ХХК 2025 оны гуравдугаар улиралд тус бүр нь 77.9 тонны жинтэй 2 ширхэг хүнд тоног төхөөрөмжийг ХБНГУлсаас тээвэрлэн авчирч, Эрдэнэт үйлдвэрт хүргэсэн. Мөн “Шинэ Зуунмод” хотын дэд станцын цахилгааны тоног төхөөрөмж болох 114 тонны жинтэй 2 ширхэг трансформатор, бусад хэрэгслийн хамт нийтдээ 8 машин бүхий чиглүүлэн хамгаалуулах үйлчилгээтэй тээврийг хийж гүйцэтгэлээ.

monlogistics
TRUCKING

Монложистикс Тракинг ХХК “MINE-PRO-2025” олон улсын уул уурхайн тоног төхөөрөмжийн экспод үзүүлэнгийн зориулалтаар 120 тонн даацтай овор болон жин хэтрүү “Dump Truck”-ийг тусгай нөхцөл, зохицуулалтын дагуу амжилттай тээвэрлэлээ. Мөн FLSmidth Mongolia LLC -н хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Эрээн хотоос Эрдэнэт уурхайн чиглэлд 76 тонн бүхий жин хэтрүү уурхайн тоног төхөөрөмжийн сэлбэг, эд ангиудыг амжилттай тээвэрлэлээ.




Үйл ажиллагааны тайлан

- › Тээврийн салбарын нийт орлого
- › Монложистикс Группийн орлого
- › Тээврийн салбарын ачааны нийт хэмжээ
- › Монложистикс Группийн ачааны хэмжээ

ТЭЭВРИЙН САЛБАРЫН ОРЛОГО

/ ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР /




2025 оны 3-р улирлын байдлаар тээврийн салбарын орлого 6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 14% буурсан байна.

“Эх сурвалж: ҮСХ ийн мэдээлэл дээр үндэслэн бэлтгэсэн дотоод судалгаа болно.”

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО

/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /




Монложистикс Группийн борлуулалтын орлого 216.5 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 3% буурсан байна.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /



2025 оны 3-р улирлын байдлаар Монгол Улсын нийт ачаа тээврийн эргэлтийн хэмжээ 101 сая.тн хэмжээнд хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 4% өссөн байна.


МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /




Монложистикс группийн ачаа эргэлт 604 мян.тн хүрч өмнөх оны мөн үеэс 31% буурсан үзүүлэлттэй байна.

ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /




Монгол улсын экспортын ачаа тээвэр өмнөх оны мөн үеэс 5% өсөж 72.7 сая.тн хүрсэн байна.




Монложистикс группийн экспортын ачаа тээвэр өмнөх мөн оны үеэс 79% буурч 30 мян. тн хүрсэн байна.

ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /





Монгол улсын импортын ачаа тээвэр өмнөх оны мөн үеэс 4% өсөж 6.2 сая.тн хүрсэн байна.



Монложистикс группийн импортын ачаа тээвэр өмнөх мөн оны үеэс 1% өсөж 100 мян.тн хүрсэн байна.

ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



ОЛОН УЛС ДАХ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /





ХАЯГ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Нью хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

ХОЛБОО БАРИХ

+976 7701-5454

info@monlogistics.mn

www.mlholding.mn